

## ЭРДЭНЭ РЕСУРС ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРЭГТ 18,000 МЕТРИЙН ӨРӨМДЛӨГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Дүүргийг тэлэх хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн талбайд өрөмдлөг хийнэ

### Тойм<sup>1</sup>:

- 8 сарын 17-нд Баян Хөндийн өрөмдлөгийн үйл ажиллагаа эхэлсэн, 8 сарын 24-ний долоо хоногоос 2-р өрөмдлөгийн баг талбай дээр очсоноор хоёр өрөм зэрэг ажиллахаар төлөвлөсөн.
  - Хөтөлбөрийн нэгдүгээр үе шатанд Баян Хөндий (“БХ”) болон Хар Морь талбайд ~8,700 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
    - Баян Хөндийд нийт ~4,800 метрийн ~30 цооногийг төлөвлөсөн ил уурхайн хязгаар дотор, гадна болон Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ-д тусгасан нөөцийн хязгаараас гадна талбайд өрөмдлөгийг хийж гүйцэтгэнэ.
      - Баян Хөндийн өрөмдлөгийн хөтөлбөрт газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий хоёр талбайг шалгана.
        - Баруун өмнөд Страйкер: VKD-292 цооногт 353 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 29 г/т алтны агуулга бүхий 15 метрийг илрүүлсэн.
        - Зүүн өмнөд Мидфийлд: VKD-288 цооногт 581.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 125.9 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийг илрүүлсэн.
    - Хоёрдугаар өрөмдлөгийн баг Хар Морь талбайд нийт 1,200 метрийн 10 цооногт өрөмдлөг хийнэ.
      - Өрөмдлөгийн хөтөлбөр нь гол эрдэсжсэн структур болон суваг малталт хийсэн талбайд төвлөрөн хийгдэнэ: KMT-01, KMT-03 сувагт 50.8 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал, 45.3 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 14 г/т алтны агуулга бүхий 4 метрийг илрүүлсэн.
      - 10-р сарын эхээр нэгдүгээр үе шатны өрөмдлөгийг Баян Хөндий, Хар Морь талбайд хийж гүйцэтгэн, анхан шатны үр дүнг үргэлжлүүлэн 2,700 метрийн ~15 цооногийн хөтөлбөрийг төлөвлөсөн.
  - Хоёрдугаар үе шатанд Алтан Нар, Улаан талбайд төвлөрөн, 10-р сарын дундаас 9,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хийж гүйцэтгэнэ.
    - Хөтөлбөрийн хоёрдугаар үе шатны төлөвлөгөөг Баян Хөндий, Хар Морь талбайн нэгдүгээр үе шатны өрөмдлөгийн үр дүнгийн тайлал, хяналтад тулгуурлан эцэслэнэ.

### Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот  
2020.18.08

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс”** эсвэл **“Компани”**) нь өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Төслийн тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдлөгийн хөтөлбөр эхлүүлснийг танилцуулахад таатай байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли: “Бид 3-р улирлын эхээр газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий огтлолуудыг танилцуулсныг үргэлжлүүлж, Хөндий Алтны Дүүрэгт томоохон өрөмдлөгийн

<sup>1</sup> Энэхүү хэвлэлийн мэдээнд дурдсан өмнөх үр дүнгүүд нь бодит зузааныг илэрхийлнэ.

хөтөлбөрийг эхлүүлж байгаадаа баяртай байна.” “Эрик Спроттын оролцсон санхүүжилтийг хааснаар бид Баян Хөндий Алтны Төслийг үргэлжлүүлэн хөгжүүлэх, өнөөг хүртэл өндөр агуулга бүхий алтны нээлтүүдийг хийсэн Хөндий Алтны Дүүрэгт идэвхитэй хайгуул хийх нөөц боломжтой боллоо.”

“Баян Хөндийд хийгдэж эхэлсэн энэхүү хөтөлбөрөөр нийт 18,000 метр өрөмдлөгийг он дуусахаас өмнө гүйцэтгэхээр төлөвлөсөн. Дараагийн долоо хоногоос Хар Морь талбайд хоёрдугаар өрөмдлөгийн баг ажиллаж эхлэнэ. Энэхүү хөтөлбөр нь дүүргийн шинэ талбайнуудыг шалгах, одоогийн ордуудтай зэрэгцээ орших талбайд нөөц нэмэгдүүлэх, одоогийн нөөцийн талбайг бататгах, цаашид Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх зорилготой” хэмээн танилцууллаа.

### Өрөмдлөгийн хөтөлбөрийн тойм & төлөвлөгөө

[Хавсралт зурагтай танилцана уу]

Хөндий Алтны Дүүрэг нь Баян Хөндий ил уурхайн төлөвлөгөөт хөгжүүлэлтээс гадна хайгуулын олон боломжуудаар дүүрэн бөгөөд эдгээр боломжуудад: Баян Хөндий ордын талбайд газрын дөт гүнд хийсэн өрөмдлөг, хүдэржилтийг тэлэх боломжууд, Хар Морь талбайн нээлт, 2020 оны эхээр танилцуулсан Алтан Нарын Нээлтийн бүсийн маш өндөр агуулга бүхий талбайг нээн илрүүлсэн зэрэг багтаж байна. Хэтийн төлөв бүхий талбайн тойм болон төлөвлөсөн хөтөлбөрийн тухай мэдээллийг доор танилцуулав.

### Баян Хөндий ордын талбайд

Зүүн өмнөд Мидфийлд ба Баруун өмнөд Страйкер: 2020 оны 2-р улирлын өрөмдлөгийн үр дүнд зүүн өмнөд Мидфийлд болон баруун өмнөд Стайкер бүсүүдэд газрын дөт гүнд маш өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтүүдийг илрүүлсэн. Зүүн өмнөд Мидфийлд бүсийн тойм: VKD-288 цооногт 11.5 метрийн гүнд 581.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 125.9 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийн интервал огтолсон. VKD-288 цооноогоос хойд зүгт 40 метрт VKD-274 цооногт 14.9 метрийн гүнд 338 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 25.6 г/т алтны агуулга бүхий 25 метрийн интервал огтолсон. 2020 оны 2-р улиралд зүүн өмнөд Мидфийлдэд өрөмдсөн 18 цооногийн 16-д нь алтны аномаль эрдэсжилт огтолсон бөгөөд эдгээр нь бүгд газрын гадаргаас 25 метрийн гүнд байв. Энэхүү нээлтийг баруун хойш чиглэлтэй кварц-адулярын бүлэг судлууд, хойш-урагш чиглэлтэй хэмээн таамаглаж буй тэжээгч структурын огтлол хэмээн тайлж байна. Өнгөрсөн өрөмдлөгийн хөтөлбөрөөр тодорхойлсон бүсээс хойд зүгт 50 метрт шалгасан бөгөөд зүүн өмнөд зүгт судлын дагуу 200 метрийн шалгагдаагүй талбай байна. Нэгдүгээр үе шатны хөтөлбөрөөр энэхүү таамаглаж буй тэжээгч структур өмнө зүгт буюу судалгаа хийгдээгүй бүсэд үргэлжилж буй эсэхийг шалгана. Өнөөгийн нөөцийн тооцоололд зорилтот бүсийн хаягдал эсвэл бага агуулга бүхий овоолгын материалд ангилсан бүс нь ирээдүйд төслийн ашиглалтын хугацаанд эерэгээр нөлөөлөх боломжтой. Төлөвлөсөн уурхайн хязгаарын гадна зүүн зүгт 200 метрт 157 г/т алтны өндөр агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон нь зэрэгцээ гинжин структур байх боломжийг илэрхийлдэг бөгөөд энэхүү шинэ тайллыг үргэлжлүүлэн бататгах шаардлагатай.

Баруун өмнөд Страйкер бүсэд газрын гадаргаас 25 метр гүнд 100м\*50м талбайд 11 цооног өрөмдөн, аномаль алт ( $\geq 0.2$  г/т) огтолсон. VKD-290 цооногт амсраас 8 метрээс эхлэн 91.2 г/т алтны агуулга бүхий 1 метрийг багтаасан 5.9 г/т алтны агуулга бүхий 20 метрийн интервал огтолсон. VKD-292 цооног 0.9 метрийн гүнээс эхлэн 353 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 29 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон. Ил уурхайн хаягдал эсвэл бага агуулга бүхий овоолгын материалд ангилагдсан бүсүүдийн эрдэсжилтийг шалгаснаар ийнхүү маш өндөр агуулга бүхий бүсийг илрүүлсэн бөгөөд энэхүү бүс нь ашиглалтын эхний жилд олборлохоор төлөвлөсөн бүс юм. Түүнээс гадна өнгөрсөн өрөмдлөгийн хөтөлбөрөөр баруун зүгт тэлэх боломжийг танилцуулсан бөгөөд одоогийн өрөмдлөгийн хөтөлбөрөөр өмнө зүгт тэлэх боломжийг судлана.

Баян Хөндий – Төлөвлөсөн уурхайн хязгаарыг тэлэх боломж ба хайгуул: Баян Хөндийн эрдсийн нөөцөд<sup>2</sup> 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц (“Measured and Indicated Resources”), 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц<sup>3</sup> (“Proven and Probable Reserve”) багтаж байна. ([Хэвлэлийн мэдээтэй энд танилцана уу.](#)) Баян Хөндийн төлөвлөсөн ил уурхайгаас гадна хэд хэдэн эрдэсжсэн бүс болон хайгуулын талбайг тодорхойлсон нь маш өндөр алтны агуулга бүхий хэд хэдэн судлууд (1 метрийн турш 30-150 г/т алтны агуулга бүхий интервал) огтолсон.

Өнөөгийн нөөцийн талбайг тэлж, хөгжүүлэлтийн үед баттай болон бодитой, боломжит нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой. Түүнээс гадна, одоогийн тайлагнасан нөөц нь ил уурхайгаар хязгаарлагдсан бөгөөд хязгаарын гадна алтны эрдэсжсэн бүсүүд тодорхойлогдсон. Эдгээр бүсүүдийг нэгдүгээр үе шатанд судалж, нөөцийг тэлэх боломжийг эрэлхийлнэ.

Баруун болон өмнөд Страйкер бүсийн тэлэлт: Баян Хөндий ил уурхайн төлөвлөсөн хананаас баруун зүгт 210 метрт оршдог энэхүү талбайд 2019 оны 2-р улиралд өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, өнөөг хүртэл талбайд тодорхойлсон хамгийн өндөр агуулга буюу 136 метрийн босоо гүнд 40 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон (BKD-265). BKD-265 цооногоор мөн дөт гүнд эрдэсжсэн бүс үргэлжилж байгааг тодорхойлсон, үүнд: 28 метр гүнд 2.7 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал агуулсан 1.1 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал илрүүлсэн. 2019 оны 2-р улиралд төлөвлөсөн уурхайн хананаас баруун хойд зүгт 250 метрт одоогийн нөөцийн хязгаараас гадна BKD-266 цооногийг өрөмдсөн. Энэхүү цооногоор 264 метрийн гүнд 51.9 г/т өндөр алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолж цахиур-иллит ба магнетитийн хувиралд орсон галт уулын чулуулгийн өргөн бүсийг огтолсон нь Баян Хөндийн уурхайн одоогийн тодорхойлсон өндөр агуулга бүхий эрдэсжилтийн үргэлжлэл болон доош сунасан байх боломжтойг харуулж байна. 2020 оны өрөмдлөгийн хөтөлбөрөөр баруун Страйкер бүсийн өндөр агуулга бүхий цөмөөс гадна өмнө зүгт тэлэх боломжийг судална.

### Хар Морь (“Dark Horse”)

Баян Хөндий ордоос зүүн хойш 3.5 км-т Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог Хар Морь талбайд нэгдүгээр болон хоёрдугаар үе шатны хөтөлбөрүүд хэрэгжинэ. Хар Морь талбай нь 1.5км x 3км бөгөөд Алтан сум алтны хэтийн төлөв бүхий талбайтай залгаа юм. Алтан сум талбайн өмнө зүгт туслах структурын (Хар Морь талбайгаас 300 метрт орших) дагуу хийсэн өрөмдлөгөөр өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүн буюу газрын гадаргаас 75 метрийн гүнд 24 г/т-70 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал огтолсон.

Өрөмдлөгийн хөтөлбөр нь 1.3 км талбайд хөрсөнд илэрсэн алтны аномаль бүхий гол эрдэсжсэн структурыг судлана. Энэхүү талбайд сүүлийн суваг малталтын судалгаагаар доорх үр дүнгүүд гарсан:

- Хар Морь талбайн үндсэн структурт KMT-01 суваг малталтаар 50.8 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал илрүүлсэн.
- KMT-01 сувгаас зүүн өмнө зүгт 850 метрт структурын огтлолд KMT-03 суваг малталтаар 45.3 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 14 г/т алтны агуулга бүхий 4 метрийг илрүүлээ.

<sup>2</sup> Баттай болон бодитой геологийн нөөц: 171,000 унц баттай, 350,000 унц бодитой геологийн нөөц багтаж байна. Геологийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR- 2019 оны 12 сарын 4-нд Тетра Тек боловсруулсан Баян Хөндий алтны төслийн NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

<sup>3</sup> Баян Хөндийн эрдсийн үйлдвэрлэлийн нөөц: 166,000 унц батлагдсан, 244,000 унц магадласан нөөц багтаж байна.

Хар Морь талбайн структурыг хөрсөнд илэрсэн алтны аномаль, чулуулгийн дээжлэлтээр илэрсэн маш өндөр алтны агуулга, кварцын биетийн үлдэгдэл, эрчимтэй цахиуржилт болон цагаан гялтгануурын хувирал хэмээн тодорхойлогддог. Хар Морь талбайн одоогийн тайллаар зүүн хойд чиглэлийн хагарлуудын дагуу, баруун хойд чиглэлийн хагарлуудтай огтлолцох гол зүүн хойд структурын дагуу байрласан комб кварц штокверк нягтралуудаар хянагдсан алтны цуварсан эрдэсжилтийг агуулсан хэмээн ойлгогдож байна. Энэхүү эсрэг структууруудын огтлол нь шингэн урсгал болон дараалсан алтны давхарга үүсгэхэд тааламжтай бүсийг бий болгох боломжтой. (Хавсралт зурагтай танилцана уу).

Хар Морь талбайд хязгаарлагдмал судалгаа хийсэн, судлын дагуу томоохон нээлт хийх боломжтой бөгөөд зүүн хойд-баруун хойд структурын огтлолтой ойролцоо хөрсөнд хэд хэдэн тусгаарлагдсан боловч хүчтэй хувирсан алтны аномаль илэрсэн. Хоёрдугаар үе шатны хөтөлбөрийн төлөвлөгөөг эхний үр дүнгүүд дээр тулгуурлан гаргана.

### Алтан Нар алт полиметаллын орд

Алтан Нар төсөл нь Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 16 км оршдог нөөц нь өсөн нэмэгдэх боломжтой алт, полиметаллын орд юм. Алтан Нард одоогоор 2.0 г/т алтны агуулга бүхий 318,000 унц бодитой нөөц, мөнгө болон суурь металлын нөөц дээр 1.7 г/т алтны агуулга бүхий 186,000 унц боломжит нөөцийг агуулж байна.

Компанийн 100% эзэмшдэг Алтан Нар төслийн 5.6 км эрдэсжсэн бүсэд багтаж буй 18 хэтийн төлөв бүхий талбайн нэг буюу Нээлтийн Бүс ("Discovery Zone")-д 2020 оны эхээр өндөр агуулга бүхий нээлтийг танилцуулсан. TND-135 цооногт 17 г/т алт, 44.7 г/т мөнгө, 0.75% хар тугалга, 1.47% цайрын агуулгатай 23 метр интервал бүхий хар, сульфидоор баяжсан эпитеpmаль брекчийг огтолсон. TND-135 цооногийн өрөмдлөгийн үр дүнд Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий цөм, түүний хэмжээ болон өндөр агуулга үргэлжилж байгааг тодорхойлж, Нээлтийн Бүсийн нөөцийг ирээдүйд нэмэгдүүлэх боломж буйг харуулсан. Тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул судалгаа хязгаарлагдмал хийгдсэн бөгөөд 2018 онд RPMGlobal-ийн боловсруулсан NI 43-101 тайланд тусгагдсан нөөцийн 90% нь газрын дөт гүнд буюу 150 метрт агуулагдаж байна. Нөөц нь хэтийн төлөв бүхий 18 талбайн 2-т агуулагдаж, суналын дагуу болон гүндээ нээлттэй байна. 2020 оны 1-р улирлын үр дүнд Нээлтийн Бүсийн цөмийн хэмжээ болон агуулга үргэлжилж буйг баталсан нь ирээдүйд тэлэх боломжтойг харуулж байна. Wave Geophysics нь Алтан Нар төслийн тайллын судалгааг хийж байгаа бөгөөд үр дүнг нь 2020 оны хоёрдугаар үе шатанд хийх өрөмдлөгийн хөтөлбөрийг боловсруулахад ашиглана.

### COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд:

2020 оны хайгуулын улиралд, компани нь аюулгүй, үр дүнтэй хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэн ажилласан. Компани нь COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна. Хээрийн ажлын хүрээнд гараа тогтмол угаах, байнгын ариутгал цэвэрлэгээ хийх зэргээр агааржуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ажилтнуудаа халдвараас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Өдөр тутам сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгч, танилцуулга хийн, зочин хүлээн авах журмыг шинэчилж, биеийн халууныг шалгах ажлыг тогтмолжууллаа. Шаардлагатай нөхцөлд ашиглах зорилгоор тусгаарлах байр, хувийн хамгаалалтын хэрэгслүүдийг бэлтгэсэн. Нэгдүгээр сараас эхлэн Монгол Улсын засгийн газар олон улсад зорчих иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүх шатны хичээл сургалтын үйл ажиллагааг хязгаарлах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох зэргээр иргэдээ вирусээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлж байна. 2020 оны 8 сарын 31 хүртэл одоогийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан. 2020 оны 8 сарын 18-ны байдлаар Монгол Улсад дотооддоо вирусний тархалт болон нас баралт бүртгэгдээгүй. Нийт батлагдсан болон тайлагнасан халдварууд нь олон улсын зорчих хөдөлгөөнөөс үүдсэн.

## Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд<sup>1</sup> 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц (“Measured and Indicated Resources”)<sup>2</sup>, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. ([Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу.](#)) Баттай болон бодитой нөөц, боломжит<sup>4</sup> нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7 сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус эцсийн ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. ([Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу](#)) Эцсийн ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор алтыг ялган авахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

## Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic

<sup>4</sup> Эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд Тетра Тек-ийн боловсруулсан Хөндий Алтны Төслийн NI 43-101 техникийн тайлантай танилцана уу.

<sup>2</sup> Баттай болон бодитой геологийн нөөц: 171,000 унц баттай, 349,700 унц бодитой геологийн нөөц

gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

### Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>


LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

Зураг 1: Хөндий Алтны Дүүргийн эрдэсжсэн бүсүүд

# ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСӨЛ

Гурван орд, хэтийн төлөв бүхий талбай, хязгаарлагдмал судлагдсан бүс  
*Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь*



- Хайгуулын тусгай зөвшөөрөл
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл
- Эрдэсжсэн бүс
- Au
- Cu
- Ag
- Mo
- Pb
- Zn




## ХАР МОРЬ ТАЛБАЙ

### БАЯН ХӨНДИЙ

2020 оны 3-р улирлын өрөмдлөгийн  
хөтөлбөр нэгдүгээр үе шат:

Тусгай зөвшөөрлийн талбайд 8700 м  
өрөмдлөг хийнэ

*Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь*



### БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ОРД:

Зүүн урд Мидфийлд бүс  
Баруун урд Страйкер бүс



Чулуулгийн дээж

- > 10 г/т
- > 5-10 г/т
- 1-5 г/т
- Цооног
- Структур

1570 (max)  
Gold in Soil (ppb)  
6



## БАЯН ХӨНДИЙ:

### Ил уурхайтай залгаа орших тэлэх боломжтой бүсүүд

Олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэх нь

- Баттай ба Бодитой нөөц: 3.16 г/т алтны агуулга бүхий 521,000 унц
- Боломжтой нөөц: 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц
- Мидфийлд, баруун урд бүсэд газрын дөт гүнд маш өндөр агуулга илэрсэн
- Уурхайн хананаас урд болон хойд зүгт нөөцийг тэлэх боломжтой



БАЯН ХӨНДИЙ ТЭЛЭЛТ БОЛОН  
ӨРӨМДЛӨГИЙН БҮС

- Q2-2020 өрөмдлөгийн бүс
- Өндөр агуулгатай бүс
- Бага агуулгатай бүс
- Хайгуул-тэлэлтийн бүс

500м

